



Эгэх хариуцлага ба үнэлгээ

Raymond Gervais

2023



Агуулга

Энэ хэсэгт:

- ❖ ҮДСУ-ын тайлагналын шаардлагууд
- ❖ Үнэлгээний элементүүд: тодорхойлолт ба онцлог шинжүүд

ҮДСУ нь доорхи зүйлд төвлөрнө

- Бодит үр дүн (зорилт)-г тодорхойлж, хэрэгжүүлэх
- Үр дүнтэй үзүүлэлтүүдийг ашиглан явцын байдлыг хянах, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг тайлагнах хэмжилтийн системийг хэрэгжүүлэх
- Хүссэн үр дүнд хүрэхийн тулд болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох ба удирдах
- Сургамжуудыг нэгтгэх замаар байгууллагын шийдвэр гаргалтын үр дүн, оновчтой байдлыг сайжруулах

үргэлжлэл

5. Ахиц амжилтыг ХЯНАХ

Бид өөрсдийн байгаа нөөц бололцооны хүрээнд хүссэн үр дүндээ хүрч байна гэж хэрхэн дүгнэх вэ?

6. Гарсан үр дүн, зарцуулсан нөөцийг ТАЙЛАГНАХ

Манай хэлтсээс гадуур юу болж байгаа талаар бид хэрхэн мэдээлж, харилцаж болох вэ?

7. СУРАЛЦСАН ЗҮЙЛЭЭ нэгтгэх

Байгууллагын шийдвэр гаргах, үр ашигтай, үр дүнтэй байдлыг сайжруулахын тулд цуглуулсан мэдээллийг бид хэрхэн ашиглах вэ?

ТАЙЛАГНАХ



ҮДСУ-ийн тайлангийн шаардлага юу вэ?

- Үр дүнд суурилсан тайлан нь бодит **үр дүнгийн** тухай гүйцэтгэлийн түүх юм;
- Гүйцэтгэлийн хэмжилтийн хүрээн дэх **шалгуур үзүүлэлт**үүдийн талаар цуглуулсан мэдээллээр үүнийг нотолсон;
- Өгөгдлийг **логик загвараас** хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулсан;
- Энэ хоёрын хоорондох аливаа **зөрүүг** тайлбарлах ёстой; Аливаа зөрүү нь тэдгээрийн ач холбогдол, төсөлд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг агуулсан байх ёстой;
- Шинжилгээнд гарсан аливаа **эрсдэл**, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаар ярилцах ёстой.

Өгөгдлөөс гадна: сургамж

Гүйцэтгэлийн түүхийн нэмэлт зүйл бол гүйцэтгэл болон үнэлгээний тайланд тусгагдсан сургамж юм.

OECD-ийн дагуу ямар сургамж авсан бэ?

Шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлийг сайжруулж, **бусад орчинд илүү сайн** үр дүнд хүрэхэд түлхэц болохуйц олдворуудыг **НЭГТГЭХ ШИНЖЛЭХ**, дүн шинжилгээг тайлж ойлгох.

Ихэнхдээ сургамж нь гүйцэтгэл, үр дүнд нөлөөлдөг арга хэмжээг бэлтгэх, төлөвлөх, хэрэгжүүлэхэд давуу болон сул талуудыг онцолж өгдөг. Сургамж нь эерэг, төвийг сахисан эсвэл сөрөг байж болно.

Үнэлгээ



Нэр томъёоны тодорхойлолт

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, 2002 :

Хэрэгжиж буй болон дуусгавар болсон төсөл, хөтөлбөр, бодлогын дизайн (арга, аргачлалын хүрээ), хэрэгжилт, үр дүнгийн системчилсэн, объектив үнэлгээг. Уг үнэлгээгээр зорилтуудын харилцан хамаарал, биелэлт, хөгжлийн үр ашиг, үр дүнтэй байдал, нөлөөлөл, тогтвортой байдлыг тодорхойлох зорилготой. Үнэлгээний тоо мэдээлэл нь найдвартай, хэрэглэгдэхүйц байх хэрэгтэй ба хүлээн авагч тал, донор байгууллагын шийдвэр гаргалтад нөлөөлөх сургамж зэргийг тусгана.

Түүнчлэн үнэлгээ нь үйл ажиллагаа, бодлого, хөтөлбөрийн үнэ цэнэ, ач холбогдлыг тодорхойлох үйл явц юм. Төлөвлөсөн, хэрэгжиж буй эсвэл дуусгавар болсон хөгжлийн интервенцийн системчилсэн, объектив үнэлгээ юм.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”

Байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж өгсөн үнэлэлтийг

Хяналт-шинжилгээ ба үнэлгээ

	Хяналт-шинжилгээ (monitoring)	Үнэлгээ (evaluation)
Хэрэглээ	Байнгын, тогтмол	Үе шаттайгаар, урьдчилан тодорхойлсон тайлант үеүдэд
Зорилт	Хэрэгжилтийн явцыг хянана	Бодлого, зорилго, зорилт хэрхэн үр дүнд хүрч байгааг тодорхойлно
Арга	Шалгуур үзүүлэлт болон урьдчилан төлөвлөсний дагуу мэдээлэл цуглуулна	Мэдээлэл цуглуулах ахисан түвшний арга ашиглах, үр нөлөөний дүн шинжилгээ хийх
Үр дүн	Явцын хяналт	Стратегийн хяналт
Ерөнхий асуулт	Бид урагшилж байна уу?	Бид зөв зүйл хийж байна уу?
Тодорхойлолт	“ хяналт-шинжилгээ ” гэж байгууллагын үйл ажиллагаа болон бодлогын зорилго, зорилт, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагааг	Үнэлгээ гэж байгууллагын үйл ажиллагаа болон бодлогын зорилго, зорилт, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг системтэйгээр, объектив байдлаар хийсэн үнэлгээг хэлнэ. Үнэлгээг хэрэгжилтийн дунд шатанд болон төгсгөлд төлөвлөгөөт байдлаар давтамжтай хийдэг.

Үнэлгээний онцлог шинж


Үнэлгээ нь дараах онцлог шинжтэй:

- Хэрэглээнд тулгуурлсан – ажил, үйл ажиллагаа
- Практикт хэрэглэгдэхүйц үр дүнг бий болгох
- Оролцогчдод үр ашигтай байх

Үнэлгээгээр хийсэн ажил нь субъектив дүгнэлт биш, харин бодитой, системтэй, нарийн дэс дараатай хийгдсэн байх ёстой.

Үнэлгээний гол асуултууд

- Үнэлгээний цөм нь үнэлгээний гол асуултууд юм. Үнэлгээний үйл явцын бусад бүх хэсгүүд эдгээр асуултуудаар чиглүүлэгдэж явдаг.
- Үнэлгээний асуултууд нь үнэлгээний хил хязгаар, хамрах хүрээг бүрдүүлдэг бөгөөд үнэлгээ нь юуг анхаарах, юуг анхаарахгүйг бусдад мэдээлэх зорилготой.



Үнэлгээний асуултуудын жишээ

Үр дүнгийн тодорхойлолт	Үнэлгээний асуулт
Х аймгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар сайжирсан	Эрүүл мэндийн мэргэжилтнүүд үйлчлүүлэгчид хандах журмыг хэр зэрэг хэрэгжүүлж чадсан бэ?
Улаанбаатар хотын нийтийн тээвэрт эрсдэл буурлаа	Хөтөлбөрийн амьдралын мөчлөгийн туршид янз бүрийн төрлийн эрсдэлүүд хэрхэн өөрчлөгдсөн бэ?
Үндэсний шинэчлэлийг хэрэгжүүлэхэд дээд боловсролын оруулах хувь нэмэр нэмэгдэнэ	Хөтөлбөрийн 5 жилийн хугацаанд үндэсний бодлогыг хэрэгжүүлэхэд дээд боловсрол ямар үүрэг гүйцэтгэсэн бэ?
Малын тэжээлийн үйлдвэрлэлийн түвшин нэмэгдсэн	Малчид байгальд ээлтэй тэжээл бэлтгэх аргыг хэр эзэмшсэн бэ?

Асуултын төрлүүд:

- **Тойм:** Одоогийн төлөв байдал:
- Юу вэ?
- Үр нөлөө болон гарцын үзүүлэлтүүдийн өөрчлөлт
- **Норматив:** харьцуулалт:
- Юу байх ёстой
- Хүлээгдэж буй үр дүн/ зорилт
- Үр нөлөө ба гарцын гүйцэтгэл
- **Шалтгаан ба үр дагавар:**
- Хөтөлбөр өөрчлөлтийн шалтгаан болсон уу?
- Ямар үр нөлөөг хэнд

ЭЗХАХБ-Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд


- ✓ Ач холбогдол/
Relevance
 - Оролцогч талууд болон үр шим хүртэгчдийн хэрэгцээ шаардлага, тэргүүлэх зорилтод нийцсэн байдал
- ✓ Үр дүнтэй/
Effectiveness
 - Хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд зорилтдоо хүрч буй эсэх
- ✓ Үр ашиг/
Efficiency
 - Зарцуулсан нөөц (орц) болон бүтээгдэхүүн үйлчилгээ (гарц) хамаарал
- ✓ Нөлөөлөл/
Impact
 - Үр дүнд гарч буй бүх өөрчлөлтүүд
- ✓ Тогтвортой байдал/
Sustainability
 - Бодлого, төсөл, хөтөлбөр дууссаны дараа ч гарсаар байх үр шим

Үнэлгээний үр дүнг үр дүнтэй мэдээлэх

- Үнэлгээний эцсийн тайлан нь үр дүнг зорилтот хүмүүст хүргэхэд хангалтгүй юм.
- Харилцаа холбооны төлөвлөгөөтэй байх ёстой
- Үр дүнтэй мэдээллэх, үр дүнг түгээхэд харилцаа холбооны хэд хэдэн сувгууд болон бүтээгдэхүүн шаардлагатай.
- Үр дүнтэй тайлан гаргахын тулд дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг санал болгож байна.
 - Товч хураангуй
 - Оршил
 - Үнэлгээний арга, аргачлал
 - Үнэлгээний үр дүн
 - Дүгнэлт
 - Зөвлөмж

Үйл ажиллагааны төлөвлөгөө

Хөтөлбөрийн үнэлгээний хамгийн чухал ашиг тусын нэг бол сайжруулалт хийх хэрэгцээг тодорхойлдог юм.



Дасгал ажил - 5

Тайлагнах: Үр дүнгийн тодорхойлолттой холбоотой нэг сургамжийг тодорхойлно үү?

Үнэлгээ: Хоёр өөр үр дүнгийн тодорхойлолт дээр хоёр үнэлгээний асуултыг зохио.



ᠭᠢᠯᠠᠢᠯᠠᠭ᠎ᠠ

“Гялайлаа”





Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

Address: Floor 3, National Times News Tower Khudaldaanii
gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

Phone: 7610-5000